



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ, ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБА

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД 2022 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улаанбаатар хот
2023 он



Бэлтгэсэн: Статистикийн сангийн эрхлэгч, цагдаагийн ахмад С.Энхбаатар
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Э.Батгэрэл
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Амаржаргал
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ч.Баатарсүрэн
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Д.Гэрэлцэцэг
Ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Уянга
Мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Тамир

Хянасан: Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дарга,
цагдаагийн хурандаа П.Батбаатар
Статистик, мэдээллийн хэлтсийн дарга,
цагдаагийн дэд хурандаа Д.Жанчивдорж

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.


ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ (2022)



НИЙТ 35340 +39.0%

+47.0% 24310 НИЙСЛЭЛД

ОРОН НУТАГТ 11019 +24.1%




АНГИЛАЛ




- Өмчлөх эрхийн эсрэг (60.82%)
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг (26.39%)
- Бусад (12.8%)

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН БАЙДАЛ



- Хөнгөн (86.67%)
- Хүнд (13.33%)






- 06-14 цагт (30.01%)
- 14-19 цагт (31.1%)

ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОГЧ

НИЙТ 23665 +30.9%

ЭРЭГТЭЙ
19195 +26.7%

ЭМЭГТЭЙ
+52.7% 4470



Нас	Эрэгтэй	Эмэгтэй
60+	250	51
45-59	2155	457
35-44	3599	763
18-34	12027	2823
0-17	1164	376



АЖИЛГҮЙ

13553 +32.4%



СОГТУУГААР

6427 +20.6%



МАНСУУРСАН

232 +34.9%



ЯЛ ШИЙТГЭГДЭЖ
БАЙСАН



3147 +20.3%

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

НИЙТ 35220 +40.9%


ЭРЭГТЭЙ
19121 +39.4%

ЭМЭГТЭЙ
+42.8% 16099



845	60+	729
3654	45-59	3481
5124	35-44	4389
8426	18-34	6558
1072	0-17	942

нас



ХҮҮХЭД

2014 +47.5%



НАС БАРСАН ХҮН

766 +12.2%



ГЭМТЭСЭН ХҮН

10310 +24.2%



УЧИРСАН ХОХИРОЛ

347900.1 сая төгрөг



НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН

52.7% +5.1%



ГАРЧИГ


ГАРЧИГ	3
НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	4
ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	13
ГУРАВ. ОРОН НУТАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ	62
ДӨРӨВ. ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ	172
4.1 Хүнийг алах гэмт хэрэг	172
4.2 Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	175
4.3 Хүчиндэх гэмт хэрэг	178
4.4 Хулгайлах гэмт хэрэг	181
4.5 Хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг	184
4.6 Халаасны хулгайн гэмт хэрэг	187
4.7 Мал хулгайлах гэмт хэрэг	190
4.8 Дээрэмдэх гэмт хэрэг	193
4.9 Залилах гэмт хэрэг	196
4.10 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг	199
4.11 Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	201
4.12 Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг	204
4.13 Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг	207
4.14 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэрэг	211
ТАВ. ГЭМТ ХЭРГИЙН ОНЦЛОГ, НӨХЦӨЛ БАЙДАЛ	214
5.1 Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	214
5.2 Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	217
5.3 Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг	221
5.4 Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг	225
5.5 Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	228
ЗУРГАА. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ХҮНИЙ ОНЦЛОГ	232
6.1 Эмэгтэй хүн үйлдсэн гэмт хэрэг	232
6.2 Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг	235
6.3 Гадаадын иргэнээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил	238



НЭГ. ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Хүлээн авч шалгасан гомдол, мэдээлэл.

Цагдаагийн байгууллага 2022 онд иргэн, аж ахуйн нэгжээс 657.650 дуудлага мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 309.572 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 42.351 буюу 15.8 хувиар өсч, гэмт хэргийн шинжтэй 97.007 /31.3%/, зөрчлийн шинжтэй 206.840 /66.8%/ гомдол мэдээллийг шийдвэрлэсэн байна.



2022 онд 5725 гомдол, мэдээлэл буюу нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 1.9 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

2.1. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.

-Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 35340, Улаанбаатар хотод 24310 /68.8%/, орон нутагт 11019 /31.1%/, бусад газар /хилийн чанадад/ үйлдэгдсэн 11 /0.1%/ гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- Улсын хэмжээнд нийт 9911 хэрэг буюу 39.0%,
- Нийслэлийн хэмжээнд 7776 хэрэг буюу 47.0%,
- Орон нутгийн хэмжээнд 2139 хэрэг буюу 24.1%-аар тус тус өсч,
- Бусад газар /хилийн чанадад/-т 4 хэрэг буюу 26.7%-аар буурсан байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 30628 буюу 86.7 хувь нь хөнгөн, 4712 буюу 13.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 38.6 хувиар, хүнд гэмт хэрэг 41.2 хувиар тус тус өссөн байна.

УЛСЫН ХЭМЖЭЭНД

35340 +39.0%

НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД


24310 +47.0%

ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД

11019 +24.1%



Сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг.




2.2. 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг.



Орон нутагт бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 843 буюу 7.7 хувийг Хөвсгөл аймагт, 775 буюу 7.0 хувийг Сэлэнгэ аймагт, 754 буюу 6.8 хувь нь Төв аймагт, нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6293 буюу 25.9 хувийг Баянзүрх дүүрэгт, 4523 буюу 18.6 хувийг Баянгол дүүрэгт, 3626 буюу 14.9 хувийг Сүхбаатар дүүрэгт тус тус бүртгэгдсэн нь хамгийн их байна.



2.3. Сүүлийн 12 сард бүртгэгдсэн гэмт хэрэг /тухайн сар/.



2.4. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	448	532	18.8	1.5
	Үүнээс: Хүнийг алах	194	199	2.6	0.6
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7637	9325	22.1	26.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	118	98	-16.9	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	540	678	25.6	1.9
	Үүнээс: Хүчиндэх	439	550	25.3	1.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	210	238	13.3	0.7
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	2	4	2.0 дах	0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	28	35	25.0	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	31	54	74.2	0.2
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	13632	21493	57.7	60.8
	Үүнээс: Хулгайлах	4579	6077	32.7	17.2
	Дээрэмдэх	366	485	32.5	1.4
	Залилах	6558	11839	80.5	33.5
	Малын хулгай	743	778	4.7	2.2
9	Эдийн засгийн гэмт хэрэг	158	162	2.5	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	-	-	0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	756	359	-52.5	1.0
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	52	94	80.8	0.3
13	Авлигын гэмт хэрэг	15	13	-13.3	0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	232	296	27.6	0.8
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	601	559	-7.0	1.6
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	8	9	12.5	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	151	259	71.5	0.7
18	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	915	1220	33.3	3.5
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	912	1214	33.1	3.4
19	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	11	10	-9.1	0.0
20	Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	-	-	-	-





2.5. Гэмт хэргийн бүтцэд хамгийн өндөр хувь эзэлж буй гэмт хэргийн төрөл.



- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (60.82%)
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (26.39%)
- Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг (3.45%)
- Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг (1.92%)
- Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг (1.51%)
- Бусад (5.92%)

Өмчлөх эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 87.2 хувийг эзэлж байна.

2.6. Бүртгэгдсэн гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.





Үзүүлэлт	2021 он	2022 он	Зөрүү		Нийт гэмт хэрэгт ээлэх хувь
			Тоо	Хувь	
Цаг					
06:00-14:00	7361	10696	3335	45.3	30.3
14:00-19:00	7691	11023	3332	43.3	31.2
19:00-22:00	3759	5029	1270	33.8	14.2
22:00-06:00	6618	8592	1974	29.8	24.3
Гараг					
Даваа	3833	5335	1502	39.2	15.1
Мягмар	3879	5360	1481	38.2	15.2
Лхагва	3881	5231	1350	34.8	14.8
Пүрэв	3814	5079	1265	33.2	14.4
Баасан	3771	5577	1806	47.9	15.8
Бямба	3137	4407	1270	40.5	12.5
Ням	3114	4351	1237	39.7	12.3
Газар					
Гэр, орон сууц	9940	12449	2509	25.2	35.2
Бусад газар	5440	7129	1689	31.0	20.2
Гудамж талбай	4757	6949	2192	46.1	19.7
Олон нийтийн газар	2021	3634	1613	79.8	10.3
Аж ахуйн нэгж	1858	3109	1251	67.3	8.8
Авто зам	909	1192	283	31.1	3.4
Төрийн байгууллага	230	525	295	2.3 дах	1.5
Төрийн бус байгууллага	160	188	28	17.5	0.5
Нийтийн тээвэр	114	165	51	44.7	0.5

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 11023 буюу 31.2 хувь нь 14:00-19:00 цагт, 10696 буюу 30.3 хувь нь 06:00-14:00 цагт, 5577 буюу 15.8 хувь нь баасан, 5360 буюу 15.2 хувь нь мягмар гарагт, 12449 буюу 35.2 хувь нь гэр, орон сууцанд, 6949 буюу 19.7 хувь нь гудамж, талбайд тус тус бүртгэгдсэн байгаа нь хамгийн их байна.

Өмнөх оны мөн үеийнхээс 14:00-19:00 цагт бүртгэгдсэн гэмт хэрэг 43.3 хувиар, 06:00-14:00 цагт бүртгэгдсэн гэмт хэрэг 45.3 хувиар, баасан гарагт бүртгэгдсэн гэмт хэрэг 47.9 хувиар, мягмар гарагт бүртгэгдсэн гэмт хэрэг 38.2 хувиар, гэр, орон сууцанд бүртгэгдсэн гэмт хэрэг 25.2 хувиар, гудамж, талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 46.1 хувиар тус тус өссөн байна.

2.7. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 5821 буюу 16.5 хувь нь согтуугаар, 5249 буюу 14.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 1540 буюу 4.4 хувь нь бүлэглэн, 1258 буюу 3.6 хувь нь хүүхэд оролцож, 1729 буюу 4.9 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.






Гурав. Гэмт хэргийн илрүүлэлт.

3.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.


Улсын хэмжээнд 54.2 хувь, нийслэлд 52.0 хувь, орон нутагт 60.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 1.5, нийслэлд 1.7, орон нутагт 1.6 нэгжээр тус тус өссөн.

3.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 29900 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 10595 хэрэг буюу 54.9, үүнээс 16209 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 6036 буюу 59.3 хувиар тус тус өссөн.



3.3. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэгдээгүй 13691 гэмт хэрэг.




Дөрөв. Гэмт хэрэгт холбогдогч.

4.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.


Нийт 23665 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5587 буюу 30.9 хувиар өссөн.

Холбогдогчдын 4470 буюу 18.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1543 буюу 52.7 хувиар, 1540 буюу 6.5 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 619 буюу 67.2 хувиар тус тус өссөн байна.





4.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс.




Нийт гэмт хэрэгт холбогдогчдын 26.9 хувь нь 18-24 насны, 16.8 хувь нь 25-29 насны залуучууд байгаа бол 57.3 хувь нь ажилгүй, 3921 буюу 16.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч байна. Гадаадын 53 иргэн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 34 буюу 2.8 дахин өссөн байна.


Тав. Гэмт хэргийн хохирогч, хохирлын хэмжээ.

5.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 35220 хүн, 87 хуулийн этгээд хохирч, үүнээс 766 хүн нас барж, 10310 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт хохирогч 10226 буюу 40.9, гэмтсэн хүн 2011 буюу 24.2, нас барсан хүн 83 буюу 12.2 хувиар тус тус өссөн байна.



5.2. Учирсан хохирол.



/Сая төгрөгөөр/

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 347900.1 сая төгрөгийн хохирлын 183243.9 сая төгрөг буюу 52.7 хувийг нөхөн төлүүлж, 5695.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеийнхээс хохирлын хэмжээ 167526.2 сая төгрөг буюу 92.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 92841.1 сая төгрөг буюу 2.0 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 846.2 сая төгрөг буюу 12.9 хувиар буурсан байна.




Зургаа. Зөрчил.

6.1. Нийт бүртгэгдсэн зөрчил.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 2.704.791 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 630.379 буюу 30.4 хувиар, 2.701.773 зөрчлийг шийдвэрлэсэн нь 631.823 буюу 30.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6.2 Бүртгэгдсэн зөрчлийн ангилал.



6.3. Шийдвэрлэлт.

Зөрчил гаргасан 2.561.390 иргэн, 75.401 хуулийн этгээдийг 92.0 тэрбум төгрөгөөр торгох, 18.931 хүнийг баривчлах, 46.051 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл тус тус ногдуулсан байна.


Торгосон хүн	2021 он	2022 он	Зөрүү
	1.960.507	2.561.390	+30.6%
Хуулийн этгээд	60.708	75.401	+24.2%
Торгуулийн хэмжээ /сая төгрөг/	75021.7	92019.9	+22.7%
Баривчлуулсан	15.277	18.931	+23.9%
Торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан	33.458	46.051	+37.6%



6.4. Сogгууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон этгээдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа.

63879 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6600 буюу 9.4 хувиар буурсан. Эрүүлжүүлэгдсэн хүний 51597 буюу 80.8 хувь нь Улаанбаатар хотод, 12282 буюу 19.2 хувь нь орон нутагт эрүүлжүүлэгдсэн байна.

6.5. Сүүлийн 10 жилд эрүүлжүүлэгдсэн хүний тоо.



Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 58180 буюу 91.1 хувь нь эрэгтэй, 5699 буюу 8.9 хувь нь эмэгтэй, 112 буюу 0.2 хувь нь 18 хүртэлх насны хүмүүс байна.

Архины албадан эмчилгээнд 440 хүн, сайн дурын эмчилгээнд 937 хүнийг хамруулсан байна.

---oooOooo---



ХОЁР. НИЙСЛЭЛ, ДҮҮРГҮҮДЭД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн хэмжээнд 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 220663 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 73631 буюу 33.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 147032 буюу 66.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 35252 буюу 19.0 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 24838 буюу 50.9 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 10414 буюу 7.6 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 17132 буюу 23.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 52921 буюу 71.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 462 буюу 0.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 100433 буюу 68.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 45296 буюу 30.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 235 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 24.310 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7776 буюу 47.0 хувиар өсч, улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 69.0 хувийг эзэлж байна. Сүүлийн 10 жилийн дунджаар жилд 19.174, сард 1597, хоногт 53, цагт 2 гэмт хэрэг үйлдэгдсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сүүлийн 20 жилээр:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг.



Д/д	Дүүрэг	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянгол	2758	4523	1765	64.0
2	Баянзүрх	4217	6293	2076	49.2
3	Сүхбаатар	2285	3626	1341	58.7
4	Сонгинохайрхан	2903	3290	387	13.3
5	Хан-Уул	2045	3179	1134	55.5
6	Чингэлтэй	1864	2848	984	52.8
7	Багануур	163	201	38	23.3
8	Багахангай	20	21	1	5.0
9	Налайх	279	329	50	17.9



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 21726 буюу 89.4 хувь нь хөнгөн, 2584 буюу 10.6 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 47.2 хувиар, хүнд гэмт хэрэг 45.9 хувиар тус тус өссөн байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	272	315	15.8	1.3
	Үүнээс: Хүнийг алах	109	103	-5.5	0.4
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	4551	5787	27.2	23.8
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	49	40	-18.4	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	269	344	27.9	1.4
	Үүнээс: Хүчиндэх	225	285	26.7	1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	139	193	38.8	0.8
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	-	3		0.0
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	20	26	30.0	0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	27	46	70.4	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	9785	16087	64.4	66.2
8	Үүнээс: Хулгайлах	3283	4179	27.3	17.2
	Дээрэмдэх	305	396	29.8	1.6
	Залилах	5240	9810	87.2	40.4
	Мал хулгайлах	43	36	-16.3	0.1
9	Эдийн засгийн гэмт хэрэг	130	131	0.8	0.5
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	2	-		0.0
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	534	297	-44.4	1.2
12	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	34	58	70.6	0.2
13	Авлигын эсрэг гэмт хэрэг	1	-		0.0
14	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	136	145	6.6	0.6
15	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	52	45	-13.5	0.2
16	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	4	5	25.0	0.0
17	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	133	231	73.7	1.0
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	443	595	34.3	2.4
18	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	442	593	34.2	2.4
	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	2	2	0.0	0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 3643 буюу 15.0 хувь нь даваа гарагт, 3640 буюу 15.0 хувь нь мягмар гарагт, 3559 буюу 14.6 хувь нь лхагва гарагт, 3538 буюу 14.6 хувь нь пүрэв гарагт, 3951 буюу 16.3 хувь нь баасан гарагт, 3024 буюу 12.4 хувь нь бямба гарагт, 2955 буюу 12.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 8113 буюу 33.4 хувь нь 06:00-14:00 цагт, 7670 буюу 31.6 хувь нь 14:00-19:00 цагт, 3285 буюу 13.5 хувь нь 19:00-22:00 цагт, 5242 буюу 21.6 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл нийт гэмт хэргийн 8401 буюу 34.6 хувь нь гэр орон сууцанд, 5718 буюу 23.5 хувь нь гудамж талбайд, 2913 буюу 12.0 хувь нь олон нийтийн газарт, 146 буюу 0.6





хувь нь нийтийн тээвэрт, 379 буюу 1.6 хувь нь төрийн байгууллагад, 123 буюу 0.5 хувь нь төрийн бус байгууллагад, 2638 буюу 10.9 хувь нь аж ахуйн нэгжид, 622 буюу 2.6 хувь нь авто замд, 3370 буюу 13.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 2675 буюу 11.0 хувь нь согтуугаар, 4048 буюу 16.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 827 буюу 3.4 хувь нь бүлэглэн, 858 буюу 3.5 хувь нь хүүхэд оролцож, 882 буюу 3.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

Д/д	Дүүрэг	Согтуугаар	Хүүхэд оролцож	Эмэгтэй хүн оролцож	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	Бүлэглэн үйлдсэн	Галт зэвсгээр үйлдсэн
1	Баянгол	262	112	902	79	139	
2	Баянзүрх	742	321	1054	235	162	
3	Сүхбаатар	323	100	762	94	195	1
4	Сонгинохайрхан	489	116	383	216	109	
5	Хан-Уул	317	112	441	100	115	2
6	Чингэлтэй	370	81	417	98	95	
7	Багануур	87	5	20	21	4	
8	Багахангай	11		2	5	1	
9	Налайх	74	11	67	34	7	1
	Нийт	2675	858	4048	882	827	4

Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.


Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн хэргийн 10020 буюу 41.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 52.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгжээр өссөн.

Улсын гэмт хэргийн илрүүлэлттэй харьцуулахад 2.2 нэгжээр бага байна.

2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 21959 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 8196 хэрэг буюу 59.6 хувиар, үүнээс 11413 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 4496 буюу 65.0 хувиар тус тус өссөн байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/






Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 14816 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4248 буюу 40.2 хувиар өссөн. Холбогдогчдын 3379 буюу 22.8 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 56.4 хувиар, 977 буюу 6.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 64.5 хувиар, 11437 буюу 77.2 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 36.0 хувиар тус тус өссөн байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн үлмаас 23899 иргэн, 56 хуулийн этгээд хохирч, үүнээс 332 хүн нас барж, 6128 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 7839 буюу 48.8 хувиар, хохирсон хуулийн этгээд 24 буюу 75.0 хувиар, гэмтсэн хүн 1451 буюу 31.0 хувиар тус тус өсч, нас барсан хүн 7 буюу 2.1 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 284052.9 сая төгрөгийн хохирлын 55.5 хувийг нөхөн төлүүлж, 1210.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 134740.3 сая төгрөг буюу 90.2 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 83756.9 буюу 2.1 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 2316.5 сая төгрөг буюу 65.7 хувиар буурсан байна.



Тав. Зөрчил.

Нийслэлийн хэмжээнд нийт 2.075.830 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 473.217 буюу 29.5 хувиар өсч, 2.074.051 зөрчлийг шийдвэрлэсэн нь 474.226 буюу 29.6 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 1.892.361 буюу 91.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 87.451 буюу 4.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 5941 буюу 0.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 855 буюу 0.0 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 89.222 буюу 4.3 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 1.962.561 иргэн, 75.143 хуулийн этгээдийг 65290.2 сая төгрөгөөр торгох, 9165 хүнийг баривчлуулах, 27182 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс торгуулсан иргэн 447558 буюу 29.5 хувиар, баривчлуулсан иргэн 1931 буюу 26.7 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан иргэн 10147 буюу 59.6 хувиар тус тус өссөн байна.

2022 онд Нийслэлийн хэмжээнд нийт 51.597 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3405 буюу 6.2 хувиар бүүрсан байна.

---oooOooo---



2.1. БАЯНГОЛ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 34996 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 13282 буюу 38.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 21714 буюу 62.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 5748 буюу 19.7, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 1120 буюу 5.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 4628 буюу 53.5 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2820 буюу 21.2 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 9809 буюу 73.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 62 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 14130 буюу 65.1 хувийг зөрчлийн хэрэг нээж, 7370 буюу 33.9 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 49 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 4523 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1765 буюу 64.0 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 18.6 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	90	162	72	80	14	14-р хороо	69	213	144	3.1 дах
2	2-р хороо	212	325	113	53.3	15	15-р хороо	49	129	80	2.6 дах
3	3-р хороо	233	276	43	18.5	16	16-р хороо	95	199	104	2.1 дах
4	4-р хороо	133	376	243	2.8 дах	17	17-р хороо	131	224	93	71
5	5-р хороо	157	218	61	38.9	18	18-р хороо	92	196	104	2.1 дах
6	6-р хороо	141	173	32	22.7	19	19-р хороо	49	142	93	2.9 дах
7	7-р хороо	168	451	283	2.7 дах	20	20-р хороо	386	324	-62	-16.1
8	8-р хороо	117	142	25	21.4	21	21-р хороо	50	50	0	0
9	9-р хороо	46	97	51	2.1 дах	22	22-р хороо	57	98	41	71.9
10	10-р хороо	42	62	20	47.6	23	23-р хороо	29	43	14	48.3
11	11-р хороо	95	174	79	83.2	24	24-р хороо	48	77	29	60.4
12	12-р хороо	73	168	95	2.3 дах	25	25-р хороо	59	67	8	13.6
13	13-р хороо	137	121	-16	-11.7	26	26-р хороо	16	16	16	



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 4277 буюу 94.5 хувь нь хөнгөн, 246 буюу 5.5 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 63.9, хүнд хэрэг 64.0 хувиар тус тус өссөн байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	29	46	58.6	1
	Үүнээс: Хүнийг алах	9	14	55.6	0.3
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	546	775	41.9	17.1
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	2	-60	0
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	28	54	92.9	1.2
	Үүнээс: Хүчиндэх	23	42	82.6	0.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	8	15	87.5	0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	4	10	2.5 дах	0.2
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	3	-25	0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1937	3410	76	75.4
7	Хулгайлах	479	775	61.8	17.1
	Дээрэмдэх	65	88	35.4	1.9
	Залилах	1238	2212	78.7	48.9
8	Эдийн засгийн гэмт хэрэг	15	18	20	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	90	54	-40	1.2
10	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	7	7	-	0.2
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	17	13	-23.5	0.3
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	1			
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	20	38	90	0.8
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	52	80	53.8	1.8
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	52	80	53.8	1.8

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 614 буюу 13.6 хувь нь даваа гарагт, 584 буюу 12.9 хувь нь мягмар гарагт, 616 буюу 13.6 хувь нь лхагва гарагт, 725 буюу 16.0 хувь нь пүрэв гарагт, 982 буюу 21.7 хувь нь баасан гарагт, 505 буюу 11.2 хувь нь бямба гарагт, 497 буюу 11.0 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1406 буюу 31.1 хувь нь 06:00-14:00 цагт, 1477 буюу 32.7 хувь нь 14:00-19:00 цагт, 538 буюу 11.9 хувь нь 19:00-22:00 цагт, 1102 буюу 24.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 1459 буюу 32.2 хувь нь гэр орон сууцанд, 993 буюу 22.0 хувь нь гудамж талбайд, 814 буюу 18.0 хувь нь олон нийтийн газарт, 22 буюу 0.5 хувь нь нийтийн тээвэрт, 237 буюу 5.2 хувь нь төрийн байгууллагад, 32 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 460 буюу 10.2 хувь нь аж ахуйн нэгжид, 85 буюу 1.9 хувь нь авто замд, 421 буюу 9.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.






1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 262 буюу 5.7 хувь нь согтуугаар, 902 буюу 19.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 139 буюу 3.0 хувь нь бүлэглэн, 112 буюу 2.4 хувь нь хүүхэд оролцож, 79 буюу 1.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 7011 хэрэгт хэрэг бүртгэлт, 320 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 7331 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 1824 урьд оны үлдэгдэл хэрэг, 5294 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 4, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 209 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4694 буюу 64.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2083 буюу 44.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 1147 буюу 24.4 хувийг шүүхэд шилжүүлж,
- 167 буюу 3.5 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 1248 буюу 26.5 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 49 буюу 1.0 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 85.0 хувь, хуулийн анхны хугацаанд 88.5 хувийг шийдвэрлэж 132 хүнд холбогдох 2686 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянгол дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1284 буюу 28.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 52.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс -4.4 нэгжээр буурсан.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 0.6 нэгжээр их байна.





2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 4339 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1957 хэрэг буюу 82.2 хувиар, 2284 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 926 буюу 68.2 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2673 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.1 хувиар өссөн. Холбогдогчдын 1896 буюу 70.9 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.6 хувиар, 777 буюу 29.1 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 64.6 хувиар, 126 буюу 4.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 2.2 дахин тус тус өссөн байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.





Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 4422 иргэн, 3 хуулийн этгээд хохирч, 51 хүн нас барж, 838 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 1754 буюу 65.7 хувиар, нас барсан хүн 16 буюу 45.7 хувиар, гэмтсэн хүн 234 буюу 38.7 хувиар тус тус өссөн.

4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 36399.7 сая төгрөгийн хохирлын 22672.9 сая төгрөг буюу 62.3 хувийг нөхөн төлүүлж, 44.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 16928.7 сая төгрөг буюу 86.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 15674.9 сая төгрөг буюу 3.2 дахин өсч, битүүмжилсэн хөрөнгө 1752.8 сая төгрөг буюу 97.6 хувиар буурсан байна.



Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянгол дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 127200 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 21101 буюу 19.9 хувиар, 127040 зөрчлийг шийдвэрлэсэн нь 21304 буюу 20.1 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 98658 буюу 77.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 20254 буюу 15.9 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 548 буюу 0.4 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 122 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 7618 буюу 6.0 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 122112 иргэн, 454 хуулийн этгээдийг 4542045.5 мянган төгрөгөөр торгож, 854 хүнийг баривчлуулах, 3620 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 20477 буюу 20.1 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 1183 буюу 48.5 хувиар тус тус өсч, баривчилсан шийтгэл 13 буюу 1.5 хувиар бүүрсан байна.

2022 онд Баянгол дүүрэгт нийт 6697 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 810 буюу 13.7 хувиар өссөн байна.

---oooOooo---



2.2. БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 53340 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 19760 буюу 37.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 33580 буюу 63.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 19760 буюу 37.0 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 7153 буюу 56.7 хувиар тус тус өсч, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл буюу 2.7 хувиар буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 4442 буюу 22.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 14451 буюу 73.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 92 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 22832 буюу 68.0 хувийг зөрчлийн хэрэг нээж, 10472 буюу 31.2 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 17 буюу 0.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 6293 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2076 буюу 49.2 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 25.9 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	173	343	170	98.3	22	22-р хороо	139	149	10	7.2
2	2-р хороо	343	336	-7	-2	23	23-р хороо	116	232	116	2.0 дах
3	3-р хороо	123	200	77	62.6	24	24-р хороо	47	47	0	0
4	4-р хороо	271	269	-2	-0.7	25	25-р хороо	129	143	14	10.9
5	5-р хороо	227	252	25	11	26	26-р хороо	185	294	109	58.9
6	6-р хороо	171	210	39	22.8	27	27-р хороо	122	393	271	3.2 дах
7	7-р хороо	132	211	79	59.8	28	28-р хороо	105	296	191	2.8 дах
8	8-р хороо	256	455	199	77.7	29	29-р хороо		9	-	-
9	9-р хороо	115	174	59	51.3	30	30-р хороо		18	-	-
10	10-р хороо	109	166	57	52.3	31	31-р хороо		16	-	-
11	11-р хороо	136	210	74	54.4	32	32-р хороо		7	-	-
12	12-р хороо	117	197	80	68.4	33	33-р хороо		2	-	-
13	13-р хороо	100	185	85	85	34	34-р хороо		7	-	-
14	14-р хороо	349	345	-4	-1.1	35	36-р хороо		16	-	-
15	15-р хороо	107	93	-14	-13.1	36	37-р хороо		2	-	-
16	16-р хороо	149	268	119	79.9	37	38-р хороо		7	-	-
17	17-р хороо	57	92	35	61.4	38	39-р хороо		9	-	-
18	18-р хороо	119	174	55	46.2	39	40-р хороо		4	-	-
19	19-р хороо	88	104	16	18.2	40	41-р хороо		7	-	-
20	20-р хороо	109	181	72	66.1	41	42-р хороо		24	-	-
21	21-р хороо	123	132	9	7.3	42	43-р хороо		14	-	-



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 5479 буюу 87.1 хувь нь хөнгөн, 814 буюу 12.9 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 46.6, хүнд хэрэг 69.6 хувиар тус тус өссөн байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг Үүнээс: Хүнийг алах	95 27	105 30	10.5 11.1	1.7 0.5
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1221 8	1503 13	23.1 62.5	23.9 0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг Үүнээс: Хүчиндэх	77 68	95 75	23.4 10.3	1.5 1.2
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	33	65	97.0	1.0
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	7	1	-85.7	0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	8	12	50.0	0.2
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	2408	4133	71.6	65.7
7	Үүнээс: Хулгайлах	840	981	16.8	15.6
	Дээрэмдэх	77	110	42.9	1.7
	Залилах	1286	2613	2.0 дах	41.5
8	Эдийн засгийн гэмт хэрэг	28	40	42.9	0.6
9	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1	-	-	-
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	166	85	-48.8	1.4
11	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	11	14	27.3	0.2
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	37	32	-13.5	0.5
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	17	7	-58.8	0.1
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11	82	7.5 дах	1.3
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	96	119	24.0	1.9
15	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	95	119	25.3	1.9
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	-	-	0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 966 буюу 15.4 хувь нь даваа гарагт, 976 буюу 15.5 хувь нь мягмар гарагт, 956 буюу 15.2 хувь нь лхагва гарагт, 850 буюу 13.5 хувь нь пүрэв гарагт, 908 буюу 14.4 хувь нь баасан гарагт, 807 буюу 12.8 хувь нь бямба гарагт, 830 буюу 13.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 2045 буюу 32.5 хувь нь 06:00-14:00 цагт, 1926 буюу 30.6 хувь нь 14:00-19:00 цагт, 1059 буюу 16.8 хувь нь 19:00-22:00 цагт, 1263 буюу 20.1 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 2202 буюу 35.0 хувь нь гэр орон сууцанд, 1558 буюу 24.8 хувь нь гудамж талбайд, 662 буюу 10.5 хувь нь олон нийтийн газарт, 49 буюу 0.8 хувь нь нийтийн тээвэрт, 37 буюу 0.6 хувь





нь төрийн байгууллагад, 24 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 386 буюу 6.1 хувь нь аж ахуйн нэгжид, 125 буюу 2.0 хувь нь авто замд, 1250 буюу 19.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 742 буюу 11.7 хувь нь согтуугаар, 1054 буюу 16.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 162 буюу 2.6 хувь нь бүлэглэн, 321 буюу 5.1 хувь нь хүүхэд оролцож, 235 буюу 3.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 12674 хэрэгт хэрэг бүртгэлт, 1028 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 13702 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 4703 урьд оны үлдэгдэл хэрэг, 8254 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 745 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 9113 буюу 66.5 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 4781 буюу 52.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 2457 буюу 27.0 хувийг шүүхэд шилжүүлж,
- 546 буюу 6.0 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 1174 буюу 12.9 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 155 буюу 1.7 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 66.5 хувь, хуулийн анхны хугацаанд 91.7 хувийг шийдэж, 299 хүнд холбогдох 4697 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Баянзүрх дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 2776 буюу 44.1 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 51.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.5 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 0.4 хувиар бага байна.

Илрүүлэлтийн хувь /хэргийн ангиллаар/



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 5770 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2285 хэрэг буюу 65.6 хувиар, 2978 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 1372 буюу 85.4 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 3668 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46.3 хувиар өссөн. Холбогдогчдын 2742 буюу 74.8 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.6 хувиар, 926 буюу 25.2 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 66.2 хувиар, 343 буюу 9.3 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 96.0 хувиар тус тус өссөн байна.

3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.







Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 6081 иргэн, 25 хуулийн этгээд хохирч, 95 хүн нас барж, 1541 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 2040 буюу 50.5 хувиар, гэмтсэн хүн 294 буюу 23.6 хувиар тус тус өсч, нас барсан хүн 6 буюу 5.9 хувиар буурсан.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 45867.4 сая төгрөгийн хохирлын 15859.2 сая төгрөг буюу 34.6 хувийг нөхөн төлүүлж, 218.8 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 20931.0 сая төгрөг буюу 83.9 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 5425.1 сая төгрөг буюу 52.0 хувиар тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 738.2 сая төгрөг буюу 77.1 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 204450 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 44250 буюу 27.6 хувиар, 204140 зөрчлийг шийдвэрлэсэн нь 44586 буюу 27.9 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 172.083 буюу 84.2 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 12534 буюу 6.1 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 2047 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 208 буюу 0.1 хувийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих, 17578 буюу 8.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 192749 иргэн, 2425 хуулийн этгээдийг 7929449.3 мянган төгрөгөөр торгох, 6087 иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 2879 хүнийг баривчлуулсан нь өмнөх оны мөн үеэс торгосон иргэн 41164 буюу 27.2 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 2214 буюу 57.2 хувиар, баривчлуулсан шийтгэл 788 буюу 37.7 хувиар тус тус өссөн байна.

2022 онд Баянзүрх дүүрэгт нийт 6359 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1057 буюу 14.3 хувиар буурсан байна.



2.3. СҮХБААТАР ДҮҮРЭГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 28339 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 10720 буюу 37.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 17619 буюу 62.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 4422 буюу 18.5 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 249 буюу 1.4 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 4173 буюу 63.7 хувиар тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2401 буюу 22.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 7780 буюу 72.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 46 буюу 0.4 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 12452 буюу 70.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 5034 буюу 28.8 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 19 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 3626 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1341 буюу 58.7 хувиар өсч, нийслэлд бүртгэгдсэн гэмт хэргийн 14.9 хувийг эзэлж байна.

Тус дүүрэгт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /хороодоор/.

Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Хороо	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	1-р хороо	590	774	184	31.2	11	11-р хороо	184	438	254	2.4 дах
2	2-р хороо	35	72	37	2.1 дах	12	12-р хороо	75	104	29	38.7
3	3-р хороо	112	202	90	80.4	13	13-р хороо	81	98	17	21
4	4-р хороо	93	94	1	1.1	14	14-р хороо	45	87	42	93.3
5	5-р хороо	43	83	40	93	15	15-р хороо	33	62	29	87.9
6	6-р хороо	130	255	125	96.2	16	16-р хороо	66	90	24	36.4
7	7-р хороо	124	120	-4	-3.2	17	17-р хороо	28	57	29	2.0 дах
8	8-р хороо	247	457	210	85	18	18-р хороо	45	67	22	48.9
9	9-р хороо	139	182	43	30.9	19	19-р хороо	51	95	44	86.3
10	10-р хороо	105	208	103	98.1	20	20-р хороо	59	81	22	37.3



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 3271 буюу 90.2 хувь нь хөнгөн, 355 буюу 9.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 58.9, хүнд хэрэг 56.4 хувиар тус тус өссөн байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	25	19	-24.0	0.5
	Үүнээс: Хүнийг алах	11	8	-27.3	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	526	743	41.3	20.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	6	20.0	0.2
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	37	44	18.9	1.2
	Үүнээс: Хүчиндэх	29	35	20.7	1.0
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	44	53	20.5	1.5
3	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг		1		0.0
4	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	5	8	60.0	0.2
5	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	4	19	4.8 дах	0.5
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	1428	2485	74.0	68.5
6	Үүнээс: Хулгайлах	440	611	38.9	16.9
	Дээрэмдэх	26	50	92.3	1.4
	Залилах	836	1610	92.6	44.4
7	Эдийн засгийн гэмт хэрэг	19	25	31.6	0.7
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	63	52	-17.5	1.4
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	10	16	60.0	0.4
10	Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	1			0.0
11	Авлигын эсрэг гэмт хэрэг	1			0.0
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	35	41	17.1	1.1
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	4	8	2.0 дах	0.2
14	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг	2			
15	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	31	30	-3.2	0.8
16	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	50	82	64.0	2.3
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	50	81	62.0	2.2

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.


Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 582 буюу 16.1 хувь нь даваа гарагт, 584 буюу 16.1 хувь нь мягмар гарагт, 509 буюу 14.0 хувь нь лхагва гарагт, 583 буюу 16.1 хувь нь пүрэв гарагт, 570 буюу 15.7 хувь нь баасан гарагт, 418 буюу 11.5 хувь нь бямба гарагт, 380 буюу 10.5 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 1506 буюу 41.5 хувь нь 06:00-14:00 цагт, 1090 буюу 30.1 хувь нь 14:00-19:00 цагт, 331 буюу 9.1 хувь нь 19:00-22:00 цагт, 699 буюу 19.3 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 852 буюу 23.5 хувь нь гэр орон сууцанд, 1043 буюу 28.8 хувь нь гудамж талбайд, 463 буюу 12.8 хувь нь олон нийтийн газарт, 6 буюу 0.2 хувь нь нийтийн тээвэрт, 34 буюу 0.9 хувь нь төрийн байгууллагад, 22 буюу 0.6 хувь нь төрийн бус





байгууллагад, 861 буюу 23.7 хувь нь аж ахуйн нэгжид, 84 буюу 2.3 хувь нь авто замд, 261 буюу 7.2 хувь нь бусад газарт бүртгэгджээ.



1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 323 буюу 8.9 хувь нь согтуугаар, 762 буюу 21.0 хувь нь эмэгтэй хүн оролцож, 195 буюу 5.4 хувь нь бүлэглэн, 100 буюу 2.8 хувь нь хүүхэд оролцож, 94 буюу 2.6 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 5937 хэрэгт хэрэг бүртгэлт, 675 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 6612 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 1775 урьд оны үлдэгдэл хэрэг, 4635 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 202 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 4604 буюу 69.6 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 2170 буюу 47.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 1684 буюу 36.6 хувийг шүүхэд шилжүүлж,
- 123 буюу 2.7 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 593 буюу 12.9 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 34 буюу 0.7 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргээс хуулийн анхны хугацаанд 83.1 хувийг шийдэж 171 хүнд холбогдох 2074 хэргийн үлдэгдэлтэй байна.






Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт нийт бүртгэгдсэн хэргийн 1694 буюу 46.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 53.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.1 нэгжээр өссөн.

Нийслэлийн илрүүлэлттэй харьцуулахад 1.0 хувиар их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 3034 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1448 хэрэг буюу 91.3 хувиар, 1609 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 864 буюу 2.2 дахин тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 2429 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.4 хувиар өссөн. Холбогдогчдын 1763 буюу 72.6 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.8 хувиар, 666 буюу 27.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 2.1 дахин, 119 буюу 4.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар тус тус өссөн байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.



Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.


4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 3564 иргэн, 6 хуулийн этгээд хохирч, 24 хүн нас барж, 794 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 1329 буюу 59.5 хувиар, гэмтсэн хүн 220 буюу 38.3 хувиар тус тус өсч, нас барсан хүн 9 буюу 27.3 хувиар буурсан байна.





4.2. Учирсан хохирол.




Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 243 буюу 31.3 хувь нь гэр орон сууцанд, 75 буюу 9.7 хувь нь гудамж талбайд, 59 буюу 7.6 хувь нь олон нийтийн газарт, 35 буюу 4.5 хувь нь аж ахуйн нэгжид, 45 буюу 5.8 хувь нь авто замд, 318 буюу 41.1 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 222 буюу 28.6 хувь нь согтуугаар, 86 буюу 11.1 хувь нь эмэгтэй хүн оролцож, 41 буюу 5.3 хувь нь бүлэглэн, 37 буюу 4.8 хувь нь хүүхэд оролцож, 57 буюу 7.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 1045 хэрэгт хэрэг бүртгэлт, 199 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1244 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 333 урьд оны үлдэгдэл хэрэг, 902 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 9 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 794 буюу 63.8 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 288 буюу 36.3 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 428 буюу 53.9 хувийг шүүхэд шилжүүлж,
- 43 буюу 5.4 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 31 буюу 3.9 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 4 буюу 0.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 63.8 хувь, хуулийн анхны хугацаанд 85.0 хувийг шийдэж, 462 гэмт хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Сэлэнгэ аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 313 буюу 40.3 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 48.8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.0 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 11.7 нэгжээр бага байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 609 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 134 хэрэг буюу 28.2 хувиар, үүнээс гэмт хэргийн 297 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 32 буюу 12.1 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.



3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 506 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 хувиар өссөн байна.



Холбогдогчдын 69 буюу 13.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар, 43 буюу 8.5 хувийг хүүхэд эзэлж байгаа 2.3 дахин тус тус өсч, 437 буюу 86.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 0.7 хувиар буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 822 иргэн, 3 хуулийн этгээд хохирч, үүнээс 23 хүн нас барж, 291 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 178 буюу 27.6 хувь, гэмтсэн хүн 4 буюу 1.4 хувиар өсч, нас барсан хүн 1 буюу 4.2 хувиар буурсан байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 5663.9 сая төгрөгийн хохирлын 2377.2 сая төгрөг буюу 42.0 хувийг нөхөн төлүүлж, 305.4 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 3402.2 сая төгрөг буюу 2.5 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1169.3 сая төгрөг буюу 96.8 хувиар өсч, битүүмжилсэн хөрөнгө 469.8 сая төгрөг буюу 60.6 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.

Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 36150 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12714 буюу 54.2 хувиар, 36029 зөрчлийг шийдвэрлэсэн нь 12770 буюу 54.9 хувиар тус тус өссө байна.



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 32123 буюу 88.9 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 561 буюу 1.6 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 320 буюу 0.9 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3146 буюу 8.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 34260 иргэнийг 1674484.5 мянган төгрөгөөр торгох, 642 хүнийг баривчилах, 1116 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 12426 буюу 56.9 хувиар, баривчилсан шийтгэл 214 буюу 50.0 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 123 буюу 12.4 хувиар тус тус өссөн байна.

2022 онд Сэлэнгэ аймагт нийт 1071 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 78 буюу 7.9 хувиар өссөн байна.

---oooOooo---



3.17. ТӨВ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.

Төв аймгийн цагдаагийн газар 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 4519 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1750 буюу 38.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2769 буюу 61.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 220 буюу 4.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 319 буюу 10.3 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 99 буюу 6.0 хувиар өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 485 буюу 27.7 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 1192 буюу 68.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 19 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2594 буюу 93.7 хувийг зөрчлийн хэрэг нээж, 101 буюу 3.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 52 буюу 1.9 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 754 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 143 буюу 23.4 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.8 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алтанбулаг	21	17	-4	-19.0	15	Дэлгэрхаан	4	5	1	25.0
2	Аргалант	25	33	8	32.0	16	Жаргалант	32	30	-2	-6.3
3	Архуст	7	2	-5	-71.4	17	Заамар	59	69	10	16.9
4	Батсүмбэр	38	54	16	42.1	18	Зуунмод	109	163	54	49.5
5	Баян	15	20	5	33.3	19	Лүн сум	18	29	11	61.1
6	Баяндэлгэр	11	12	1	9.1	20	Мөнгөн-морьт	11	16	5	45.5
7	Баянжаргалан	8	10	2	25.0	21	Өндөрширээт	11	16	5	45.5
8	Баян-өнжүүл	19	12	-7	-36.8	22	Сүмбэр	2	6	4	3.0 дах
9	Баянхангай	6	16	10	2.6 дах	23	Сэргэлэн	32	51	19	59.4
10	Баянцагаан	6	13	7	2.1 дах	24	Угтаалцайдам	4	18	14	4.5 дах
11	Баянцогт	11	12	1	9.1	25	Цээл	11	17	6	54.5
12	Баянчандмань	18	17	-1	-5.6	26	Эрдэнэ	55	62	7	12.7
13	Борнуур	41	27	-14	-34.1	27	Эрдэнэсант	30	21	-9	-30.0
14	Бүрэн	7	6	-1	-14.3						



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 620 буюу 82.2 хувь нь хөнгөн, 134 буюу 17.8 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 18.3 хувиар, хүнд гэмт хэрэг 54.0 хувиар тус тус өссөн байна.

1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	14	26	85.7	3.4
	Үүнээс: Хүнийг алах	5	13	2.6 дах	1.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	256	281	9.8	37.3
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	8	2	-75.0	0.3
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	18	20.0	2.4
	Үүнээс: Хүчиндэх	11	14	27.3	1.9
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	2	-50.0	0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			0.0
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	188	296	57.4	39.3
6	Хулгайлах	96	138	43.8	18.3
	Дээрэмдэх	1	4	4.0 дах	0.5
	Залилах	22	71	3.2 дах	9.4
	Мал хулгайлах	39	61	56.4	8.1
7	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг		2		0.3
8		2			0.0
9	Эдийн засгийн гэмт хэрэг	1	5	5.0 дах	0.7
10	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	15	4	-73.3	0.5
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	10	1	-90.0	0.1
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг	55	33	-40.0	4.4
13	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.1
14	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	50	84	68.0	11.1
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	50	84	68.0	11.1
15	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг		1		0.1

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 112 буюу 14.9 хувь нь даваа гарагт, 113 буюу 15.0 хувь нь мягмар гарагт, 118 буюу 15.6 хувь нь лхагва гарагт, 80 буюу 10.6 хувь нь пүрэв гарагт, 119 буюу 15.8 хувь нь баасан гарагт, 112 буюу 14.9 хувь нь бямба гарагт, 100 буюу 13.2 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 149 буюу 19.8 хувь нь 06:00-14:00 цагт, 215 буюу 28.5 хувь нь 14:00-19:00 цагт, 152 буюу 20.2 хувь нь 19:00-22:00 цагт, 238 буюу 31.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 208 буюу 27.6 хувь нь гэр орон сууцанд, 53 буюу 7.0 хувь нь гудамж талбайд, 25 буюу 3.3 хувь нь олон нийтийн газарт, 25 буюу 3.3 хувь нь аж ахуйн нэгжид, 67 буюу 8.9 хувь нь авто замд, 376 буюу 49.9 хувь нь бусад газарт бүртгэгджээ.






1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 212 буюу 28.1 хувь нь согтуугаар, 74 буюу 9.8 хувь нь эмэгтэй хүн оролцож, 29 буюу 3.8 хувь нь бүлэглэн, 10 буюу 1.3 хувь нь хүүхэд оролцож, 54 буюу 7.2 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 1305 хэрэгт хэрэг бүртгэлт, 161 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1466 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 354 урьд оны үлдэгдэл хэрэг, 1019 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 2 хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 91 хэрэг байна. Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 1091 буюу 74.4 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 437 буюу 40.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 544 буюу 49.9 хувийг шүүхэд шилжүүлж,
- 58 буюу 5.3 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 48 буюу 4.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 4 буюу 0.4 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 74.4 хувь, хуулийн анхны хугацаанд 90.0 хувийг шийдэж, 383 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Төв аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 292 буюу 38.7 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 64.3 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.7 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 3.8 нэгжээр их байна.





2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.


Хэрэг бүртгэлтийн 663 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 280 хэрэг буюу 73.1 хувиар, үүнээс 426 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 198 буюу 86.8 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 576 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.2 хувиар өссөн байна. Холбогдогчдын 66 буюу 11.5 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 46.7 хувь, 510 буюу 88.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 9.9 хувиар тус тус өсч, 10 буюу 1.7 хувийг хүүхэд эзэлж байгаа нь өмнөх оны түвшинд байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 767 иргэн, 2 хуулийн этгээд хохирч, үүнээс 51 хүн нас барж, 361 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 143 буюу 22.9 хувиар, гэмтсэн хүн 50 буюу 16.1 хувиар, нас барсан хүн 20 буюу 64.5 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 6691.9 сая төгрөгийн хохирлын 3521.4 сая төгрөг буюу 52.6 хувийг нөхөн төлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 2947.0 сая төгрөг буюу 78.7 хувь, нөхөн төлүүлсэн хохирол 524.9 сая төгрөг буюу 17.5 хувь, битүүмжилсэн хөрөнгө 372.9 сая төгрөг буюу 2.5 дахин тус тус өссөн байна.



Тав. Зөрчил.

Төв аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 57821 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 21664 буюу 59.9 хувиар, 57812 зөрчлийг шийдвэрлэсэн нь 21788 буюу 60.5 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 51952 буюу 89.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 1289 буюу 2.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 301 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 98 буюу 0.2 хувь нь худалдаа үйлчилгээний журам зөрчих, 4181 буюу 7.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 56052 иргэн, 3 хуулийн этгээдийг 2096132.7 мянган төгрөгөөр торгох, 567 хүнийг баривчилах, 1190 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл оногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 21597 буюу 62.7 хувиар, баривчилсан шийтгэл 92 буюу 19.4 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 97 буюу 8.9 хувиар тус тус өссөн байна.

2022 онд Төв аймагт нийт 156 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 37 буюу 31.1 хувиар өссөн байна.

---oooOooo---



3.18. УВС АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Увс аймгийн цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 4005 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 854 буюу 21.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3151 буюу 78.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 552 буюу 16.0 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 499 буюу 18.8 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 53 буюу 6.6 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 312 буюу 36.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 509 буюу 59.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2655 буюу 84.3 хувийг зөрчлийн хэрэг нээж, 462 буюу 14.7 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 11 буюу 0.3 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 287 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 48 буюу 20.1 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 2.6 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Баруунтуруун	4	13	9	3.2 дах	11	Өндөрхангай	11	10	-1	-9.1
2	Бөхмөрөн	7	8	1	14.3	12	Сагил	14	9	-5	-35.7
3	Давст	6	8	2	33.3	13	Тариалан	8	9	1	12.5
4	Завхан	2	7	5	3.5 дах	14	Түргэн	9	5	-4	-44.4
5	Зүүнговь	6	8	2	33.3	15	Тэс	13	15	2	15.4
6	Зүүнхангай	5	7	2	40	16	Улаангом	93	128	35	37.6
7	Малчин	12	5	-7	-58.3	17	Ховд	6	8	2	33.3
8	Наран булаг	16	10	-6	-37.5	18	Хяргас	5	9	4	80
9	Өлгий	6	2	-4	-66.7	19	Цагаанхайрхан	5	15	10	3.0 дах
10	Өмнөговь	11	11	0	0						

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 225 буюу 78.3 хувь нь хөнгөн, 62 буюу 21.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 21.6 хувь, хүнд гэмт хэрэг нь 14.8 хувиар тус тус өссөн байна.




1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бүүрэлтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	3	2	-33.3	0.7
	Үүнээс: Хүнийг алах	2			0.0
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	66	105	59.1	36.6
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	4	2.0 дах	1.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	7	10	42.9	3.5
	Үүнээс: Хүчиндэх	6	8	33.3	2.8
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1			0.0
5	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	121	127	5.0	44.3
	Үүнээс: Хулгайлах	39	41	5.1	14.3
	Дээрэмдэх		3		1.0
	Залилах	19	28	47.4	9.8
6	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	3			0.0
7	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	15	3.8 дах	5.2
8	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	19	6	-68.4	2.1
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14	21	50.0	7.3
9	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	14	21	50.0	7.3
	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.3

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 44 буюу 15.3 хувь нь даваа гарагт, 44 буюу 15.3 хувь нь мягмар гарагт, 36 буюу 12.5 хувь нь лхагва гарагт, 37 буюу 12.9 хувь нь пүрэв гарагт, 55 буюу 19.2 хувь нь баасан гарагт, 40 буюу 13.9 хувь нь бямба гарагт, 31 буюу 10.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 62 буюу 21.6 хувь нь 06:00-14:00 цагт, 74 буюу 25.8 хувь нь 14:00-19:00 цагт, 54 буюу 18.8 хувь нь 19:00-22:00 цагт, 97 буюу 32.7 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.



Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 96 буюу 33.4 хувь нь гэр орон сууцанд, 44 буюу 15.3 хувь нь гудамж талбайд, 20 буюу 7.0 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 0.7 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.3 хувь нь төрийн бус байгууллагад, 7 буюу 2.4 хувь нь аж ахуйн нэгжид, 23 буюу 8.0 хувь нь авто замд, 94 буюу 32.8 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 129 буюу 44.9 хувь нь согтуугаар, 16 буюу 5.6 хувь нь эмэгтэй хүн оролцож, 27 буюу 9.4 хувь нь бүлэглэн, 15 буюу 5.2 хувь нь хүүхэд оролцож, 22 буюу 7.7 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.


1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 465 хэрэгт хэрэг бүртгэлт, 88 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 553 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 163 урьд оны үлдэгдэл хэрэг, 364 энэ оны дугаартай хэрэг, урьд оны түдгэлзүүлснээс сэргээсэн 3, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 23 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 409 буюу 74.0 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 153 буюу 37.4 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 239 буюу 58.4 хувийг шүүхэд шилжүүлж,
- 10 буюу 2.4 хувийг хэрэгсэхгүй болгож,


-7 буюу 1.7 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн, нийт шалгасан хэргийн 74.0 хувь, хуулийн анхны хугацаанд 66.5 хувийг шийдвэрлэж, 4 хүнд холбогдох 147 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Увс аймгийн цагдаагийн газарт нийт бүртгэгдсэн хэргийн 108 буюу 37.6 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 79.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.4 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 19.1 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 216 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 22 хэрэг буюу 11.3 хувиар, 172 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 28 буюу 19.4 хувиар тус тус өссөн байна.


Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 269 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.3 хувиар өссөн. Холбогдогчдын 254 буюу 94.4 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувиар өсч, 15 буюу 5.6 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.7 хувиар буурсан, 22 буюу 8.2 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 3.1 дахин өссөн байна.




3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 292 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 11 хүн нас барж, 117 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 47 буюу 19.2 хувиар, нас барсан хүн 1 буюу 10.0 хувиар, гэмтсэн хүн 43 буюу 58.1 хувиар тус тус өссөн.



4.2. Учирсан хохирол.



Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1101.7 сая төгрөгийн хохирлын 753.7 сая төгрөг буюу 68.4 хувийг нөхөн төлүүлж, 57.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 157.1 сая төгрөг буюу 16.6 хувиар, нөхөн төлүүлсэн хохирол 104.7 сая төгрөг буюу 16.1 хувиар тус тус өссөн, битүүмжилсэн хөрөнгө 158.7 сая төгрөг буюу 73.4 хувиар буурсан байна.

Тав. Зөрчил.


Увс аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 24523 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 5129 буюу 26.4 хувиар, 23514 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4124 буюу 21.3 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 20952 буюу 85.4 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 337 буюу 1.4 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 133 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3101 буюу 12.6 хувийг бусад зөрчил эзлэж байна.

Зөрчил гаргасан 23371 иргэн, 16 хуулийн этгээдийг 1070375.5 мянган төгрөгөөр торгох, 739 иргэнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 423 хүнийг баривчлуулсан нь өмнөх оны мөн үеэс торгосон иргэн



5156 буюу 28.3 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 35 буюу 5.0 хувиар тус тус өсч, баривчлуулсан шийтгэл 24 буюу 5.4 хувиар буурсан бүртгэгдсэн байна.



2022 онд Увс аймагт нийт 39 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 332 буюу 89.5 хувиар буурсан байна.

---oooOooo---



3.19. ХОВД АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Ховд аймгийн цагдаагийн газар нь 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 4451 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 936 буюу 21.0 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3515 буюу 79.0 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол, мэдээлэл 935 буюу 26.6 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 781 буюу 28.6 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 154 буюу 19.7 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 510 буюу 54.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 383 буюу 40.9 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 10 буюу 1.1 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2863 буюу 81.5 хувийг зөрчлийн хэрэг нээж, 620 буюу 17.6 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 24 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 538 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 122 буюу 29.3 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 4.9 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Алтай сум	15	16	1	6.7
2	Булган сум	26	46	20	76.9
3	Буянт сум	25	29	4	16.0
4	Дарви сум	11	7	-4	-36.4
5	Дөргөн сум	10	10	0	0.0
6	Дуут сум	3	7	4	2.3 дах
7	Жаргалант сум	226	281	55	24.3
8	Зэрэг сум	9	15	6	66.7
9	Манхан сум	12	16	4	33.3
10	Мөнххайрхан сум	4	10	6	2.5 дах
11	Мөст сум	9	9	0	0.0
12	Мянгад сум	14	22	8	57.1
13	Үенч сум	10	8	-2	-20.0
14	Ховд сум	17	18	1	5.9
15	Цэцэг сум	7	20	13	2.9 дах
16	Чандмань сум	9	13	4	44.4
17	Эрдэнэ-бүрэн сум	9	11	2	22.2



1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 468 буюу 87.0 хувь нь хөнгөн, 70 буюу 13.0 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн хэрэг 31.8 хувь, хүнд гэмт хэрэг нь 14.8 хувиар тус тус өссөн байна.


1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.


Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	4	6	50.0	1.1
	Үүнээс: Хүнийг алах	1	1	0.0	0.2
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	142	168	18.3	31.2
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	5	2	-60.0	0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	8	15	87.5	2.8
	Үүнээс: Хүчиндэх	5	13	2.6 дах	2.4
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	4	6	50.0	1.1
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	1			0.0
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг				0.0
7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	184	263	42.9	48.9
	Үүнээс: Хулгайлах	63	71	12.7	13.2
	Дээрэмдэх	7	4	-42.9	0.7
	Залилах	67	134	2.0 дах	24.9
8	Эдийн засгийн гэмт хэрэг	4	2	-50.0	0.4
9	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	9	2	-77.8	0.4
10	Авлигын эсрэг гэмт хэрэг	2	2	0.0	0.4
11	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	9	2.3 дах	1.7
12	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	22	23	4.5	4.3
13	Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг		1		0.2
14	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.2
15	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	31	40	29.0	7.4
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	31	39	25.8	7.2
16	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	1			0.0

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 91 буюу 16.9 хувь нь даваа гарагт, 87 буюу 16.2 хувь нь мягмар гарагт, 93 буюу 17.3 хувь нь лхагва гарагт, 76 буюу 14.1 хувь нь пүрэв гарагт, 91 буюу 16.9 хувь нь баасан гарагт, 50 буюу 9.3 хувь нь бямба гарагт, 50 буюу 9.3 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 177 буюу 32.9 хувь нь 06:00-14:00 цагт, 191 буюу 35.5 хувь нь 14:00-19:00 цагт, 57 буюу 10.6 хувь нь 19:00-22:00 цагт, 113 буюу 21.0 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 195 буюу 36.2 хувь нь гэр орон сууцанд, 64 буюу 11.9 хувь нь гудамж талбайд, 21 буюу 3.9 хувь нь олон нийтийн газарт, 10 буюу 1.9 хувь нь төрийн байгууллагад, 4 буюу 0.7 хувь нь төрийн бус байгууллагад, 26 буюу 4.8 хувь нь аж ахуйн нэгжид, 39 буюу 7.2 хувь нь авто замд, 179 буюу 33.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 154 буюу 28.6 хувь нь согтуугаар, 80 буюу 14.9 хувь нь эмэгтэй хүн оролцож, 27 буюу 5.0 хувь нь бүлэглэн, 21 буюу 3.9 хувь нь хүүхэд оролцож, 56 буюу 10.4 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 649 хэрэгт хэрэг бүртгэлт, 172 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 821 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 212 урьд оны үлдэгдэл хэрэг, 605 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн 4 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 561 буюу 68.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


- 171 буюу 30.5 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 327 буюу 58.3 хувийг шүүхэд шилжүүлж,
- 8 буюу 1.4 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 47 буюу 8.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 8 буюу 1.4 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 68.3 хувь, хуулийн анхны хугацаанд 97.3 хувийг шийдвэрлэж, 16 хүнд холбогдох, 277 хэргийн үлдэгдэлтэй байна.



Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Ховд аймгийн Цагдаагийн газарт нийт бүртгэгдсэн хэргийн 211 буюу 39.2 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 55.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.1 нэгжээр өссөн. Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 5.0 нэгжээр бага байна.





2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 380 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 154 хэрэг буюу 68.1 хувиар, 211 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 97 буюу 85.1 хувиар тус тус өссөн байна.



Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 412 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19.1 хувиар өссөн.

Холбогдогчдын 336 буюу 81.5 хувь нь эрэгтэй хүн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.3 хувиар, 76 буюу 18.4 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь 3.2 дахин тус тус өсч, 23 буюу 5.6 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 14.8 хувиар буурсан байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон иргэн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 556 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, 20 хүн нас барж, 211 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 153 буюу 38.0 хувиар өсч, нас барсан хүн 4 буюу 25.0 хувиар, гэмтсэн хүн 49 буюу 30.2 хувиар тус тус өссөн.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 1876.0 сая төгрөгийн хохирлын 1095.5 сая төгрөг буюу 58.4 хувийг нөхөн төлүүлж, 33.5 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 1013.4 сая төгрөг буюу 2.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 604.0 сая төгрөг буюу 2.2 дахин тус тус өсч, битүүмжилсэн хөрөнгө 12.0 сая төгрөг буюу 26.3 хувиар буурсан байна.



Тав. Зөрчил.

Ховд аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 27022 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6205 буюу 29.8 хувиар, 26988 зөрчлийг шийдвэрлэсэн нь 6219 буюу 29.9 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 23101 буюу 85.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 314 буюу 1.2 хувийг олон нийтийн газар биеэ зүй бусаар авч явах, 127 буюу 0.5 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 34 буюу 0.1 хувийг танхайрах, 3446 буюу 12.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 25625 иргэн, 21 хуулийн этгээдийг 1084198.8 мянган төгрөгөөр торгох, 883 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 459 хүнийг баривчлуулсан нь өмнөх оны мөн үеэс торгосон иргэн 6126 буюу 31.4 хувиар, баривчлуулсан шийтгэл 95 буюу 26.1 хувиар тус тус өсч, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 14 буюу 1.6 хувиар буурсан байна.

2022 онд Ховд аймагт нийт 1066 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 350 буюу 24.7 хувиар буурсан байна.

---oooOooo---



3.20. ХӨВСГӨЛ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Хөвсгөл аймгийн цагдаагийн газар 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 4126 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1334 буюу 32.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2792 буюу 67.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 168 буюу 3.9 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 200 буюу 6.7 хувиар тус тус буурч, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 32 буюу 2.5 хувиар өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 715 буюу 53.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 581 буюу 43.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3 буюу 0.2 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2425 буюу 86.9 хувийг зөрчлийн хэрэг нээж, 328 буюу 11.7 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 14 буюу 0.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 843 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 127 буюу 17.7 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 7.7 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Алаг-Эрдэнэ сум	254	253	-1	-0.4	13	Төмөрбулаг сум	13	10	-3	-23.1
2	Арбулаг сум	19	13	-6	-31.6	14	Түнэл сум	18	17	-1	-5.6
3	Баянзүрх сум	7	11	4	57.1	15	Улаан сум	12	21	9	75.0
4	Бүрэнтогтох сум	19	18	-1	-5.3	16	Ханх сум	5	10	5	2.0 дах
5	Галт сум	9	13	4	44.4	17	Цагаан-Уул сум	12	16	4	33.3
6	Жаргалант сум	5	10	5	2.0 дах	18	Цагаан нуур сум	4	3	-1	-25.0
7	Их-Уул сум	14	19	5	35.7	19	Цагаан-Үүр сум	2	4	2	2.0 дах
8	Мөрөн сум	225	328	103	45.8	20	Цэцэрлэг сум	4	15	11	3.8 дах
9	Рашаант сум	11	9	-2	-18.2	21	Чандмань-Өндөр сум	8	18	10	2.3 дах
10	Рэнчинлхүмбэ сум	12	5	-7	-58.3	22	Шинэ-Идэр сум	10	10	0	0.0
11	Тариалан сум	23	13	-10	-43.5	23	Эрдэнэбулган сум	5	4	-1	-20.0
12	Тосонцэнгэл сум	25	23	-2	-8.0						

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 714 буюу 84.7 хувь нь хөнгөн, 129 буюу 15.3 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 14.8 хувиар, хүнд гэмт хэрэг 37.2 хувиар тус тус өссөн байна.





1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	10	18	80.0	2.1
	Үүнээс: Хүнийг алах	5	6	20.0	0.7
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	181	239	32.0	28.4
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	2	3	50.0	0.4
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	32	2.3 дах	3.8
	Үүнээс: Хүчиндэх	13	30	2.3 дах	3.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	7	4	-42.9	0.5
5	Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг	1	1	0.0	0.1
6	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
7	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
8	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	414	475	14.7	56.3
	Үүнээс: Хулгайлах	67	97	44.8	11.5
	Дээрэмдэх	4	5	25.0	0.6
	Залилах	273	323	18.3	38.3
	Мал хулгайлах	45	20	-55.6	2.4
9	Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	3	50.0	0.4
10	Эдийн засгийн гэмт хэрэг	3	1	-66.7	0.1
11	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	12	2	-83.3	0.2
12	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	6	7	16.7	0.8
13	Хүрээлэн байгаа орчны эсрэг	40	28	-30.0	3.3
	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	26	31	19.2	3.7
14	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	26	30	15.4	3.6

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 118 буюу 14.0 хувь нь даваа гарагт, 135 буюу 16.0 хувь нь мягмар гарагт, 146 буюу 17.3 хувь нь лхагва гарагт, 102 буюу 12.0 хувь нь пүрэв гарагт, 122 буюу 14.4 хувь нь баасан гарагт, 95 буюу 11.2 хувь нь бямба гарагт, 125 буюу 14.8 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 236 буюу 28.0 хувь нь 06:00-14:00 цагт, 298 буюу 35.3 хувь нь 14:00-19:00 цагт, 119 буюу 14.1 хувь нь 19:00-22:00 цагт, 190 буюу 22.5 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 431 буюу 51.1 хувь нь гэр орон сууцанд, 96 буюу 11.3 хувь нь гудамж талбайд, 42 буюу 5.0 хувь нь олон нийтийн газарт, 16 буюу 1.8 хувь нь аж ахуйн нэгжид, 27 буюу 3.2 хувь нь авто замд, 214 буюу 25.3 хувь нь бусад газарт, 5 буюу 0.6 хувь нь төрийн бус байгууллагад, 12 буюу 1.4 хувь нь төрийн басйгууллагад тус тус бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 225 буюу 26.7 хувь нь согтуугаар, 73 буюу 8.7 хувь нь эмэгтэй хүн оролцож, 47 буюу 5.6 хувь нь бүлэглэн, 27 буюу 3.2 хувь нь хүүхэд оролцож, 74 буюу 8.8 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 931 хэрэгт хэрэг бүртгэлт, 438 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1369 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 459 урьд оны үлдэгдэл хэрэг, 901 энэ оны дугаартай, 9 нь урьд оны хэрэгсэхгүй болгосноос сэргээсэн хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 908 буюу 66.3 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:


-225 буюу 24.8 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,

-413 буюу 45.5 хувийг шүүхэд шилжүүлж,

-14 буюу 1.5 хувийг хэрэгсэхгүй болгож,

-250 буюу 27.5 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,

-6 буюу 0.7 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 66.3 хувь, хуулийн анхны хугацаанд 93.0 хувийг шийдсэн байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1 Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хөвсгөл аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 341 буюу 40.4 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 64.1 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.1 нэгжээр буурсан.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 3.6 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 410 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 154 хэрэг буюу 60.2 хувиар, үүнээс 263 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь 96 буюу 57.5 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.


3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 761 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.4 хувиар өссөн байна.



Холбогдогчдын 68 буюу 8.9 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар, 693 буюу 91.1 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 13.4 хувиар, 31 буюу 4.1 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 24.0 хувиар тус тус өссөн байна.


3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн, хуулийн этгээд.

Гэмт хэргийн улмаас 887 иргэн, 1 хуулийн этгээд хохирч, үүнээс 37 хүн нас барж, 284 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 162 буюу 22.3 хувиар, гэмтсэн хүн 60 буюу 26.8 хувиар, нас барсан хүн 15 буюу 68.2 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэн, хуулийн этгээдэд учирсан 4642.5 сая төгрөгийн хохирлын 2148.4 сая төгрөг буюу 46.3 хувийг нөхөн төлүүлж, 899.6 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 3034.7 сая төгрөг буюу 2.8 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 1168.6 сая төгрөг буюу 2.1 дахин, битүүмжилсэн хөрөнгө 864.5 сая төгрөг буюу 25.6 дахин тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Хөвсгөл аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 25237 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 719 буюу 2.9 хувиар, 25090 зөрчлийг шийдвэрлэсэн нь 678 буюу 2.8 хувиар тус тус өссөн байна.



Нийт бүртгэгдсэн зөрчлийн 21660 буюу 85.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 553 буюу 2.2 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 316 буюу 1.3 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 2708 буюу 10.7 хувийг бусад зөрчил эзэлж байна.



Зөрчил гаргасан 23675 иргэнийг 1126451.2 мянган төгрөгөөр торгох, 478 хүнийг баривчлуулах, 937 хүнийг торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеэс иргэнийг торгосон шийтгэл 546 буюу 2.4 хувиар, баривчилуулсан шийтгэл 33 буюу 7.4 хувиар, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэл 99 буюу 11.8 хувиар тус тус өссөн байна.

2022 онд Хөвсгөл аймагт нийт 417 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 41 буюу 10.9 хувиар өссөн байна.

---oooOooo---



3.21. ХЭНТИЙ АЙМАГТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.

Нэг. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

1.1. Бүртгэгдсэн гомдол, мэдээлэл.


Хэнтий аймгийн цагдаагийн газар 2022 онд иргэн, хуулийн этгээдээс 5737 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1724 буюу 30.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 4013 буюу 69.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 1447 буюу 33.7 хувиар, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 1079 буюу 36.8 хувиар, гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 368 буюу 27.1 хувиар тус тус өссөн.

Бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийн 726 буюу 42.1 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 941 буюу 54.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 12 буюу 0.7 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 2866 буюу 71.4 хувийг зөрчлийн хэрэг нээж, 1015 буюу 25.3 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 99 буюу 2.5 хувийг харьяаллын дагуу шилжүүлж тус тус шийдвэрлэсэн байна.

1.2. Бүртгэгдсэн гэмт хэрэг.

Нийт 705 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 165 буюу 30.6 хувиар өсч, орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийн 6.4 хувийг эзэлж байна.

Тус аймагт сүүлийн 20 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг:



1.3. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/.

Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт		Д/д	Сум	2021 он	2022 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь					Тоо	Хувь
1	Батноров	32	56	24	75	11	Дадал	15	29	14	93.3
2	Бат-ширээт	13	10	-3	-23.1	12	Дархан	11	13	2	18.2
3	Баянадарга	23	13	-10	-43.5	13	Дэлгэрхаан	15	27	12	80
4	Баянмөнх	8	6	-2	-25	14	Жаргалтхаан	26	27	1	3.8
5	Баян-овоо	24	22	-2	-8.3	15	Мөрөн	12	37	25	3.1 дах
6	Баянхутаг	31	36	5	16.1	16	Норовлин	25	26	1	4
7	Биндэр	27	30	3	11.1	17	Өмнөдэлгэр	21	39	18	85.7
8	Бор-Өндөр	63	69	6	9.5	18	Хэрлэн	164	219	55	33.5
9	Бэрх хот	1	2	1	2.0 дах	19	Цэнхэрмандал	12	21	9	75
10	Галшир	17	23	6	35.3						

1.4. Бүртгэгдсэн гэмт хэргийн ангилал.

Нийт бүртгэгдсэн хэргийн 510 буюу 72.3 хувь нь хөнгөн, 195 буюу 27.7 хувь нь хүнд ангиллын хэрэг байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 22.9 хувиар, хүнд гэмт хэрэг 56.0 хувиар тус тус өссөн байна.





1.5. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн бүлгээр/.

Д/д	Гэмт хэргийн төрөл	Бүртгэгдсэн хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
		2021 он	2022 он		
1	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг	17	24	41.2	3.4
	Үүнээс: Хүнийг алах	7	8	14.3	1.1
2	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	205	243	18.5	34.5
	Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1	5	5.0 дах	0.7
3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	14	21	50.0	3.0
	Үүнээс: Хүчиндэх	14	18	28.6	2.6
4	Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг	1	2	2.0 дах	0.3
5	Эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
6	Хүүхдийн эсрэг гэмт хэрэг		1		0.1
	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	268	360	34.3	51.1
7	Үүнээс Хулгайлах	79	115	45.6	16.3
	Дээрэмдэх	2	5	2.5 дах	0.7
	Залилах	48	76	58.3	10.8
	Мал хулгайлах	117	117	0.0	16.6
8	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг	4	2	-50.0	0.3
9	Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	6	3.0 дах	0.9
10	Авлигын эсрэг		1		0.1
11	Хүрээлэн байгаа орчны эсрэг	10	9	-10.0	1.3
12	Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг		1		0.1
13	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	18	34	88.9	4.8
	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих	18	34	88.9	4.8

1.6. Гэмт хэргийн үйлдэгдсэн цаг, гараг, газар.

Гэмт хэрэг бүртгэгдсэн гарагаар нь авч үзвэл 118 буюу 16.7 хувь нь даваа гарагт, 113 буюу 16.0 хувь нь мягмар гарагт, 114 буюу 16.2 хувь нь лхагва гарагт, 97 буюу 13.8 хувь нь пүрэв гарагт, 96 буюу 13.6 хувь нь баасан гарагт, 76 буюу 10.8 хувь нь бямба гарагт, 91 буюу 12.9 хувь нь ням гарагт тус тус бүртгэгдсэн бол цагаар нь авч үзвэл 130 буюу 18.4 хувь нь 06:00-14:00 цагт, 173 буюу 24.5 хувь нь 14:00-19:00 цагт, 139 буюу 19.7 хувь нь 19:00-22:00 цагт, 263 буюу 37.4 хувь нь 22:00-06:00 цагт тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 247 буюу 35.0 хувь нь гэр орон сууцанд, 88 буюу 12.5 хувь нь гудамж талбайд, 34 буюу 4.8 хувь нь олон нийтийн газарт, 1 буюу 0.1 хувь нь нийтийн тээвэрт, 5 буюу 0.7 хувь нь төрийн байгууллагад, 6 буюу 0.9 хувь нь төрийн бус байгууллагад, 24 буюу 3.4 хувь нь аж ахуйн нэгжид, 23 буюу 3.3 хувь нь авто замд, 277 буюу 39.3 хувь нь бусад газарт бүртгэгджээ.





1.7. Гэмт хэрэг үйлдсэн байдал.


Бүртгэгдсэн гэмт хэргийн 240 буюу 34.0 хувь нь согтуугаар, 65 буюу 9.2 хувь нь эмэгтэй хүн оролцож, 74 буюу 10.5 хувь нь бүлэглэн, 16 буюу 2.3 хувь нь хүүхэд оролцож, 46 буюу 6.5 хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас тус тус үйлдэгдсэн байна.

1.8. Гэмт хэргийн хөдөлгөөн.

2022 онд 932 хэрэгт хэрэг бүртгэлт, 239 хэрэгт мөрдөн байцаалт, нийт 1171 хэрэгт ЭХХШТХ-д заасан ажиллагаа явуулсны 321 урьд оны үлдэгдэл хэрэг, 830 энэ оны дугаартай хэрэг, урьд оны хэрэгсэхгүй болгосоноос сэргээсэн 19, урьд оны түдгэлзүүлсэнээс сэргээсэн 1 хэрэг байна.

Энэ хугацаанд нийт шалгасан эрүүгийн хэргийн 760 буюу 69.4 хувийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл:

- 210 буюу 27.6 хувийг хэрэг бүртгэлтийн хэрэг хааж,
- 425 буюу 55.9 хувийг шүүхэд шилжүүлж,
- 58 буюу 7.6 хувийг хэрэгсэхгүй болгож,
- 64 буюу 8.4 хувийг буюу эрүүгийн хэрэгтэй нэгтгэн,
- 3 буюу 0.5 хувийг бусад хэрэг бүртгэлтийн хэрэгтэй нэгтгэж, нийт шалгасан хэргийн 64.9 хувь, хуулийн анхны хугацаанд 99.2 хувийг шийдэж, 438 хэргийн үлдэгдэлтэй байна.




Хоёр. Гэмт хэргийн илрүүлэлт.

2.1. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь.

Хэнтий аймагт нийт бүртгэгдсэн хэргийн 330 буюу 46.8 хувийг далд аргаар үйлдсэн бөгөөд гэмт хэргийн илрүүлэлт 61.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.4 нэгжээр өссөн.

Орон нутгийн илрүүлэлттэй харьцуулахад 1.2 нэгжээр их байна.



2.2. Хэрэг бүртгэлтийн хэрэг.

Хэрэг бүртгэлтийн 532 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 207 хэрэг буюу 63.7 хувиар, үүнээс 328 гэмт хэргийн хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж ялагдагчаар татсан нь 142 буюу 76.3 хувиар тус тус өссөн байна.

Гурав. Гэмт хэрэгт холбогдогч.

3.1. Гэмт хэрэгт холбогдсон хүн.

Нийт 569 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 буюу 21.1 хувиар өссөн. Холбогдогчдын 53 буюу 9.3 хувийг эмэгтэй хүн эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар, 516 буюу 90.7 хувь нь эрэгтэй хүн байгаа нь 20.0 хувиар, 25 буюу 4.4 хувийг хүүхэд эзэлж байгаа нь 56.3 хувиар тус тус өссөн байна.




3.2. Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал.




Дөрөв. Гэмт хэргийн хохирогч, хохирол.

4.1. Хохирсон хүн.

Гэмт хэргийн улмаас 724 иргэн хохирч, үүнээс 30 хүн нас барж, 268 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал, хохирсон хүн 178 буюу 32.6 хувиар, гэмтсэн хүн 58 буюу 27.6 хувиар, нас барсан хүн 2 буюу 7.1 хувиар тус тус өссөн байна.



4.2. Учирсан хохирол.




Иргэнд учирсан 3315.7 сая төгрөгийн хохирлын 1549.9 сая төгрөг буюу 44.0 хувийг нөхөн төлүүлж, 48.0 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн нь өмнөх оны мөн үеэс хохирлын хэмжээ 1742.8 сая төгрөг буюу 2.1 дахин, нөхөн төлүүлсэн хохирол 795.7 сая төгрөг буюу 2.2 дахин, битүүмжилсэн хөрөнгө 1.2 сая төгрөг буюу 2.6 хувиар тус тус өссөн байна.

Тав. Зөрчил.

Хэнтий аймгийн цагдаагийн газрын хэмжээнд нийт 30677 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4297 буюу 16.3 хувиар, 30408 зөрчлийг шийдвэрлэсэн нь 4272 буюу 16.3 хувиар тус тус өссөн байна.

Нийт бүртгэгдсэн зөрчлийн 28412 буюу 92.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 9 буюу 0.03 хувийг олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах, 300 буюу 1.0 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 1956 буюу 6.4 хувийг бусад зөрчил эзэлж байна.



